



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/229

Булган сум

**Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээн
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн байгууллага хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жил, БНМАУ-ын баатар, Эрхэм нисгэгч Ч.Шагдарсүрэнгийн мэндэлсний 115 жилийн ойг тохиолдуулан Булган аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг Булган суманд зохион байгуулсугай.

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар баталж 761,600 (долоон зуун жаран нэг мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

4.Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд оролцох баг тамирчдын аюулгүй ажиллагааг ханган ажиллахыг Цэргийн штаб (Дайчилгааны офицер хошууч Ц.Цэрэнтогтох)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 20²⁵ оны
04 дүгээр сарын 15 нын өдрийн
А/229 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН


Ажлын хэсгийн ахлагчаар: Ц.Цэрэнтогтох (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Дайчилгааны офицер хошууч)

Гишүүдэд:

Д. Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Г. Энхбат (Могод сумын Засаг дарга)
С. Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ж. Лхагважаргал (Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбарын захирагч, дэд хурандаа)
Б. Ариунжаргал (Онцгой байдлын газрын Эмч, сэтгэл зүйч ахмад)
Э. Батхуяг (Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн ахлах мэргэжилтэн, ахмад)
Я. Нямсүрэн (Боловсрол газрын Биеийн тамир, боловсролын мэргэжилтэн)

Нарийн бичгийн даргаар: Б. Намнансүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газар Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер, дэд хурандаа)

Аймгийн Засаг даргын 2025 оны
 04 дүгээр сарын 15-ны/ний өдрийн
 А/229 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	2	3	4
1	Шагналын зардал	1,000,000	Могод сумын ЗДТГазар 1 дүгээр байрын шагнал
		800,000	ГБХЗХГазар 2 дугаар байрын шагнал
		600,000	Булган сумын ЗДТГазар 3 дугаар байрын шагнал
		400,000	ГБХЗХГазар Тусгай байр- 2*200,000
		844,000	ГБХЗХГазар Цом 1*100,000=100,000 Өргөмжлөл 3*50,000=150,000 Медаль 33ш*18,000=594,000
2	Аннос	210,000	АЗД-ийн нөөц 3х4=12 M ²
3	Шүүгчдийн зардал	350,000	АЗД-ийн нөөц 7 шүүгч *50000*=350000
4	Шатахуун	201,600	АЗД-ийн нөөц Тэмцээний бэлтгэл ажилд АИ-92 80л*2520
Нийт дүн			4,405,600